

2021 оны 07 дугаар сарын 21

Дугаар № 21/045

Улаанбаатар хот

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-д

### Хүсэлт гаргах тухай

“Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Мандал Ирээдүйн Өсөлт” хамтын хөрөнгө оруулалтын сан (цаашид “Сан” гэх) нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 1/2304 тоот анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай шийдвэрийн дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-аар дамжуулан нэгж эрхийн анхдагч зах зээлийн захиалгын бүртгэлийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахаар ажиллаж байгаа билээ.

Сан нь нийт тавин тэрбум (50,000,000,000₮) хүртэлх төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлэхээр бүртгүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар нийт захиалгын 80-аас дээш хувь буюу дөч гаруй тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлээд байна.

Сангийн нэгж эрхийн танилцуулгад заасны дагуу тавин тэрбум (50,000,000,000₮) хүртэлх хөрөнгийн 47,500,000 ширхэг нэгж эрх буюу дөчин долоон тэрбум таван зуун сая төгрөг (47,500,000,000₮)-ийг олон нийтээс татан төвлөрүүлэх ба үлдэх 2,500,000 ширхэг нэгж эрх буюу хоёр тэрбум таван зуун сая төгрөг (2,500,000,000₮)-ийн хөрөнгө оруулалтыг Сангийн хөрөнгө оруулалтын менежментийн компани болох Мандал Ассет Менежмент ХХК-аас оруулах юм.

Бидний зүгээс Сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн захиалга дөчин долоон тэрбум таван зуун сая төгрөг (47,500,000,000₮) хүрмэгц анхдагч зах зээлийн арилжааг хаалгах хүсэлтэй байна. Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ дөчин долоон тэрбум таван зуун сая төгрөг (47,500,000,000₮) хүрмэгц бид та бүхэнд албан бичгээр мэдэгдэх болно.

Түүнчлэн, хэрэв олон нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ дөчин долоон тэрбум таван зуун сая төгрөг (47,500,000,000₮)-өөс давсан тохиолдолд уг давсан хэмжээний захиалгыг Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК-с (Хуучнаар Эм Ай Би Жи ҮЦК ХХК) шивсэн захиалгаас буцаах болно. Мөн захиалга дутсан тохиолдолд Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК-с (Хуучнаар Эм Ай Би Жи ҮЦК ХХК)-с захиалга нэмэх эсвэл худалдан авах болно.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.ГАНЗОРИГ